# ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Д.НЯМ-ОСОРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах” | | | | | | | |
| 1. | Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | CAIS программд улсын хил нэвтрэх хүсэлтийг зөвхөн веб-д суурилсан загвар буюу ceps.gaali.mn, gaali.mn-ээр хүлээн авч байна. | Эхний хагас жилд:<br>-Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн байна.<br>Сүүлийн хагас жилд:<br>-Мобайл аппликейшн туршилтаар ашиглуулсан байна. | Улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа гадаад, дотоодын тээврийн хэрэгслийн улсын хилээр нэвтрэх бүртгэлийн хүсэлтийг гаалийн байгууллагад илгээх гар утсанд зориулсан програм хангамжийн хөгжүүлэлт хийлгэх шийдлийг судалж, СМТТ УТҮГ-т саналаа 2024.09.24-ний өдрийн 02-1/3895 дугаартай албан бичгээр хүргүүлж, хамтран ажилласан.<br>Дээрх асуудлыг ГЕГ-ын дэргэдэх МТГ-т шийдвэрлэх боломжгүй тул И-Монгол Академи УТҮГ-ын систем нэгтгэлийн газрын төслийн менежер С.Цэвээнсүрэн, системийн шинжээч А.Эрдэнэцэцэг, цахим засаглалын хэлтсийн процесс аналист Г. Будням, шинжээч Г.Оюунгэрэл нартай уулзалт зохион байгуулж, Е-Монголиа app-д улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, гаалийн байгууллагатай холбогдох модул гаргуулахаар тохиролцсон.<br>Үүний дагуу тээвэрлэгчээс хил нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн хүсэлт илгээх асуудлыг гар утасны програм хангамжид суурилсан хэлбэрээр цахим төлбөрийн баримтын ebarimt системээс шийдвэрлэх технологийн гарц, шийдлийг судалж, И Монгол Академи УТҮГ-т захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>-И-Монгол Академи УТҮГ-ын шинжээч нартай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлсэн.<br>-Апп-р тээврийн хэрэгслийг бүртгүүлэхэд:<br>-Иргэн регистрийн дугаараар хүсэлтээ илгээхэд 5 минут<br>-Хур системээс мэдээлэл харуулахад 1 мин буюу нийт 6 минут зарцуулдаг болно.<br>-Дээрх програмыг улсын төсвөөс зардал гаргахгүйгээр төлбөргүй хийлгэж 2024.12.15-ны өдрөөс туршилтаар нэвтрүүлнэ. | | |
| 2. | Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг CAIS-д программд бүртгэн авч хилээр нэвтрүүлэн ухаалаг гарцтай уялдуулан ажиллаж байна. Тус бүртгэл нь Хил хамгаалах ерөнхий газрын бүртгэлтэй тогтмол зөрөх хүндрэл үүсээд байна. | Эхний хагас жилд:<br>-Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна.<br>Сүүлийн хагас жилд:<br>-Ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг ижилсгэсэн байна. | -Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү гаргахгүй, мөн хилийн хяналтын байгууллагуудын давхардсан шалгалтыг багасгаж, хяналтаа сайжруулахын тулд автозамын хилийн боомтууд дээр гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулахаар хамтран ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, гаалийн байгууллагаас:<br>1.тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг өгөгдөл дамжуулах байдлаар илгээж, танай байгууллагаас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарын тодорхой мэдээллийг хүлээн авах;<br>2.хилээр түр хугацаагаар тээврийн хэрэгсэл оруулсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хилээр гарах үед нь түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгаж, нягтлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан. Үүний үр дүнд улсын хилээр орох болон гарах талд хил нэвтэрсэн авто тээврийн хэрэгслийн дугаараар ХХЕГ-аас сервисээр мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн. Тус мэдээлэлд жолооч, зорчигчийн овог, нэр, регистрийн дугаар, гадаад паспортын дугаар, төрсөн он сар өдрөөр Хил хамгаалах ерөнхий газрын баталгаажуулсан мэдээллийг хүлээн авч | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаалийн хяналт шалгалтад ашиглах, эрсдэл тооцох боломжтой болгосон. Мөн цаашид төмөр зам, агаарын тээврийн хэрэгслээр хил нэвтэрсэн зорчигчийн мэдээллийг Хил хамгаалах байгууллагын баталгаажуулсан мэдээллийг авахаар ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, хамтарсан уулзалт зохион байгуулан, сервисын мэдээллээ дахин шинэчилж хүргүүлсэн.<br>2.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх ХУН төслийн хүрээнд программ хийлгэж, автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл солилцох туршилтыг 2024 оны 11 дүгээр сард Замын-Үүд боомтод хийж, нэвтрүүлсэн. | | |
| 3. | Манифестын хяналтыг сайжруулах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2023 оны жилийн эцсийн манифестын үлдэгдэл 2,778,007 бичлэг байна. | Эхний хагас жилд:<br>-Манифестын хяналтыг сайжруулсан байна.<br>-Гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлсэн байна.<br>Сүүлийн хагас жилд:<br>-Манифестын хяналтыг сайжруулсан байна.<br>-Гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлсэн байна. | Хилээр оруулах, дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авахдаа ачааны манифестыг үндэслэж байна. Гаалийн шинэчлэлийн хүрээнд CAIS-т нэмэлт, өөрчлөлтүүд оруулж, шинээр тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмыг нэвтрүүлсэн боловч гаалийн бүрдүүлэлт хийгдсэн, үлдэгдэлгүй манифест CAIS-т хаагдахгүй алдаатай байгаа учраас хаагдаагүй манифестын тоог нэмэгдүүлж байна. Дээрх алдааг засварлуулах саналаа МТГ-т хүргүүлсэн. CAIS-ын манифестын програм дахь 2,259.822 үлдэгдлийн жагсаалтыг гаргаж, гаалийн газар, хороодын дарга нарт 2024.04.19-ний өдөр 02-1/1540, 2024.11.04-ний өдрийн 02-1/4557 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, нягтлан шалгуулсан. Үүний үр дүнд 1,623.292 манифест буюу 28.1 хувийг нь гаалийн газар, хороод нягтлан шалгаж, зохих төлөвт оруулсан.<br>Хүрсэн үр дүн: | 01.02<br>12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -2023 онд хугацаандаа хаагдаагүй импортын 19,303 манифест байсан бол 2024 онд 16,875 болж 12.5% буурсан.<br>-2023 онд хугацаандаа хаагдаагүй экспортын 1,924.707 манифест байсан бол 2024 онд 615,908 болж 67.9 % буурсан.<br>-2023 онд хугацаандаа хаагдаагүй дотоодын 11,783 манифест байсан бол 2024 онд 3,747 болж 68.1 % буурсан. | | |
| 4. | Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчид тавих хяналт. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -ГИТ-ийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг болсон.<br>-ГИТ-ийн хүсэлт ирүүлсэн 135 ААН-ийн хүсэлтийг судалж, ГЕГ-ын МЗХ-ны 3, 4, 5 дугаар сарын 3 удаагийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлсэн;<br>-CAIS->Гаалийн хяналтын бүс ->ААН ->Итгэмжлэгдсэн тээвэрлэгч->Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн жагсаалт-д 135 ААН-ийн мэдээллүүдийг тус бүр оруулж, тээвэрлэгчийн санг баяжуулсан. | Эхний хагас жилд:<br>-license.mn-ээр ирүүлсэн хүсэлтийг шалгаж, МЗХ-д танилцуулж шийдвэрлүүлсэн байна.<br>-ГИТ-ийн талаар танилцуулга бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангасан байна.<br>-ГТСМТТ УҮГ-тай license.mn-ийн хяналтыг сайжруулах чиглэлээр хамтран ажилласан байна. | ГИТ-ийн хүсэлт ирүүлсэн 135 ААН-ийн хүсэлтийг судалж, ГЕГ-ын МЗХ-ны 3 дугаар сарын 1 удаагийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлсэн;<br>-CAIS->Гаалийн хяналтын бүс ->ААН ->Итгэмжлэгдсэн тээвэрлэгч->Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн жагсаалт-д 135 ААН-ийн мэдээллүүдийг тус бүр оруулж, 212 албан бичгээр 3121 тээврийн хэрэгслийг гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн санд бүртгэж ажиллаа. | 01.02<br>03.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Эхний хагас жилд: Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна. Сүүлийн хагас жилд: Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна. | Дараах бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлтийг гаргаж, Хуулийн хэлтэст сар бүр тогтмол хүргүүлсэн:<br>Засгийн газрын тэмдэглэл:<br>-Шивээхүрэн хилийн боомтод шинээр нээсэн чингэлэг тээврийн 4 гарцыг Сэхэ боомттой холбож, өргөтгөх ажлыг БНХАУ-ын талтай дипломат шугамаар тохиролцох тухай 2022.05.11-ний өдрийн 28 дугаар тэмдэглэлийн XYI.4 дэх заалт<br>-Ашигт малтмалыг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, уурхайн эдэлбэр газар, эсхүл уурхайн амнаас худалдан авагчийн болон дамжуулан борлуулагчийн заасан талбай, гаалийн хяналтын болон түр хяналтын талбай хүртэл тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой тээврийн, зуучлалын болон эрх шилжүүлсэн зэрэг бүх төрлийн гэрээг Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системд бүртгэх арга хэмжээ авах тухай 2023.05.03-ны өдрийн 19 дүгээр тэмдэглэлийн XYIII.2.1 дэх заалт. | 01.02<br>12.10 | |
| 6 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Эхний хагас жилд: Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. Сүүлийн хагас жилд: Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. | 1.Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны 01 дугаартай албан даалгаврын хүрээнд ГСГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулж байгаа гаалийн хяналтын бүс эзэмшигч нарт хүргүүлсэн Ухаалаг гарцын систем суурилуулах шаардлагын явц, RFID-г тээврийн бүртгэлийн програмыг уялдуулах ажлаар 2024.03.25-2024.03.29-нд ГУБ М.Анхтуяагийн хамт Гашуунсухайт боомтод томилолтоор ажилласан.<br>2.ГЕГ-ын даргын 2024.04.03-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2024.04.05-2024.04.12-ны өдрийг дуустал хугацаанд RFID -ын хэвийн ажиллагааг хангах асуудлаар ШХГГ-т томилолтоор ажилласан. | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3.ESCAP, WCO-ээс 2024.04.11-ний өдрийн 15:00 цагт цахимаар зохион байгуулсан төмөр замын тээвэртэй холбоотой уулзалтад ХБГ-ын ГУАБ Ц.Цэвээндарь, МТГ-ын ГУАБ Н.Мөнхзул нарын хамт оролцсон. Уулзалтаар төмөр замын транзит тээврийг үр дүнтэй болгох, хил дамнасан цахим мэдээлэл солилцоог дэмжих төслийн зүгээс Монгол Улсын талд Бизнес процесс анализ хийх чадавхийг бэхжүүлэх чиглэлээр 2024 оны 12 дугаар сар хүртэл төсөл хэрэгжүүлэхээр болсон. Тус төслийн ажлын даалгаврыг манайх руу имэйлээр явуулж, санал авах, мөн Монгол талын зөвлөх авахаар тохирлоо.<br>4.Удирдлагаас өгсөн үүргийн дагуу ҮАБГ-т хүргүүлэх Улс хоорондын дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулсан бараанд гаалийн байгууллагаас тавьж байгаа хяналтын талаарх танилцуулгын тоон мэдээллийг бэлтгэж, 2024.06.14-ний өдөр дэд даргад viber-аар хүргүүлсэн.<br>5.АТГ-аас ирүүлсэн 2024.04.25-ны өдрийн 06/7403 дугаартай албан бичгийн дагуу Ханги боомтоор оруулсан 11-2131003-18-I01458, 11-2131003-18-I01464 дугаартай гаалийн мэдүүлэгтэй холбоотой асуудлаар 2024.04.30-ны өдрийн 11:00 цагт гэрчийн мэдүүлэг өгсөн. | | |
| 7 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээнэ. | 2024.11.30-ны байдлаар ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлсэн. 2024 онд:<br>-томилолтоор ажиллах 4;<br>-уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 5;<br>-бусад 18;<br>-хурлын өрөөний 3 буюу нийт 30 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан.<br>2024 онд CERP-д 12040 минут илүү цагаар ажилласан бичлэг байна. | 01.02<br>12.10 | 100 |

**Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Туршлага судлах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Nuctech компанийн рентгены үйлдвэрлэлийн туршлагаас судлах | ГЕГ-ын даргын 2024.06.19-ний өдрийн А/345 тушаалаар Бээжинд Nuctech компаниас зохион байгуулах рентгены үйлдвэрлэлийн үе шаттай танилцах, туршлага судлах сургалтад 2024.06.22-2024.06.27-ны өдрүүдэд оролцсон. | 06.22<br>06.27 | 100 |
| 2 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЗТХ-ийн сайдын 2024.07.09-ний өдрийн А/147 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах. | ЗТХ-ийн сайдын 2024.07.09-ний өдрийн А/147 дугаартай тушаалаар байгуулагдсан бүх төрлийн шатахуун хадгалах агуулах, буулгах төмөр зам, талбайн хүчин чадал болон төмөр замын тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авах судалгаа хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэгт ажилласан. | 07.09<br>11.30 | 100 |
| 3 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЗТ-ийн сайдын 2024.08.20-ны өдрийн А/172 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах | ЗТ-ийн Сайдын 2024.08.20-ны өдрийн А/172 тушаалаар Тяньжинд саатсан чингэлгүүдийг төмөр зам, автозамаар шуурхай тээвэрлүүлэх ажлын хэсэгт МТГ-ын ГУАБ Н.Мөнхзулын хамт ажилласан. | 08.20 | 100 |
| 4 | Уулзалт хэлэлцүүлэгт оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЦХИХХЯ-аас зохион байгуулах уулзалтад оролцох. | ЦХИХХЯ-аас 2024.09.17-ны өдөр “Шуудангийн шинэчлэл” сэдвээр зохион байгуулсан уулзалтад Б.Даваасүрэн, Н.Ойнбилэг нарын хамт оролцсон. | 09.17<br>09.17 | 100 |
| 5 | Уулзалт хэлэлцүүлэгт оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | АТГ-ээс зохион байгуулах хэлэлцүүлэгт оролцох. | АТГ, СЯ, ГЕГ, ТЕГ, СМТТ УТҮГ-аас СЯ-д хамтран 2024.10.08-ны өдөр зохион байгуулсан "Санхүү, татвар, гаалийн байгууллагын цахимжилт, түүний үр нөлөө ба иргэн, хуулийн этгээдтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх арга зам” хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон. | 10.08<br>10.08 | 100 |
| 6 | Илтгэл танилцуулах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | МХАҮТ-аас зохион байгуулах форумд оролцох. | МТЗНХ-оос “Тяньжин-Эрээн-Улаанбаатар тээврийн асуудал, гарц”, “Эдийн засгийн коридор” сэдвээр 2024.11.15-ны өдөр МХАҮТ-д 09:00 -17:00 цагт зохион байгуулагдсан форумд оролцож илтгэл танилцуулсан. | 11.15<br>11.15 | 100 |
| 7 | Танилцуулга хийх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Харилцаа холбооны зохицуулах хорооны | Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдах зөвлөлийн 2024.11.29-ний өдрийн | 11.29<br>11.29 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | удирдах зөвлөлийн хуралдаанд оролцож, мэдээлэл өгөх. | 14:00 цагийн хуралдаанд оролцож, тус зөвлөлийн дарга, 6 гишүүнд ГУБ М.Батбилэгийн хамт оролцож, хоорондын шуудан илгээмжид тавих гаалийн хяналт, бүрдүүлэлт, UPOST, гаалийн зөрчил, гаалийн хяналтын бүсийн талаарх мэдээлэл өгч, PPT танилцуулсан. | | |
| 8 | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнүүдэд хичээл заах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын СТ-өөс гаргасан хуваарийн дагуу гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнүүдэд хичээл заах | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад хамрагдаж буй 100 ажилтанд 2024.02.01-ний өдөр манифест, тээврийн бүртгэлтэй холбоотой сэдвээр хичээл заасан. | 02.01<br>02.01 | 100 |
| 9 | Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын СТ-өөс гаргасан хуваарийн дагуу гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах. | Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч 100 сонсогч нарт 2024.02.16-ны өдөр манифест, тээврийн бүртгэлтэй холбоотой сэдвээр хичээл заасан. | 02.16<br>02.16 | 100 |
| 10 | Гадаад худалдаанд оролцогч нарт хичээл заах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | “Цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан | ШУТИС-ийн Механик тээврийн сургуульд 2024.10.29-ний өдөр зохион байгуулагдсан Тээвэр логистик сэдэвт сургалтад оролцсон 80 орчим гадаад худалдаанд оролцогч ААН-ийн төлөөлөлд “Манифест, улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэл” сэдвээр хичээл заасан. | 10.29<br>10.29 | 100 |
| 11 | Цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт хичээл заах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | “Цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт хичээл заах. | ГЕГ-ын дэргэдэх СТ-өөс баталсан “Цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан сургалт”-ын хичээлийн хуваарийн дагуу 2024.12.04-ний өдрийн 13:00-13:50 цагт дамжуулан өнгөрүүлэх горим, манифест сэдвээр 18 оролцогчид хичээл заасан. | 12.04<br>12.04 | 100 |

**Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | Удирдлагын академид ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах. | Удирдлагын академид ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдсан байна. | ГЕГ-аас Удирдлагын академид хүргүүлсэн албан бичигний дагуу 2024.03.01-ний өдрөөс эхлэн 7 хоног бүрийн баасан гарагт Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, Удирдлагын академийн захирлын 2024.06.21-ний өдрийн А/436 тоот тушаалаар А4833 дугаартай сертификат авсан. | 03.01<br>06.21 | 100 |
| 2 | TABLEAU DESKTOP сургалтад хамрагдах. | Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна. | ГЕГ-т 2024 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан TABLEAU DESKTOP сургалтад хамрагдаж, өгөгдөл, мэдээлэл холбох, өгөгдлийн эх үүсвэрийг засварлах, хадгалах, Tableau Interface-ийг ашиглан үр ашиг үзүүлэх хүчирхэг дүрслэлүүд бүтээх, арифметик үйлдлүүд болон функц ашиглан тооцоолол хийх, хүснэгтэн тооцооллууд хийх, дашбоард, тайлангаа бусадтай хуваалцах талаар суралцсан. | 10.23<br>10.24 | 100 |
| 3 | Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах. | Гаалийн хэргийн англи хэлний мэдлэг дээшилж, "Glossary of international trade and customs terms"-ыг судалсан байна. | Гаалийн хэргийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор "Glossary of international trade and customs terms"-ыг судалж байна. | 01.02<br>11.30 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН
УЛСЫН БАЙЦААГЧ /Д.НЯМ-ОСОР/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Д.НЯМ-ОСОРЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

## 1.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх | 50 | 5 | 55 | |
| 2. | Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ | 55 | 5 | 60 | |
| 3. | Манифестын хяналтыг сайжруулах. | 50 | 5 | 55 | |
| 4. | Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчид тавих хяналт. | 56 | 6 | 62 | |
| 5. | Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 55 | 6 | 61 | |
| 6. | Үүрэг даалгаврын биелэлт | 55 | 5 | 60 | |
| 7. | Ажлын цаг ашиглалт | 56 | 6 | 62 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1 | Туршлага судлах | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Ажлын хэсэгт ажиллах | 60 | 10 | 70 | |
| 3 | Ажлын хэсэгт ажиллах | 60 | 10 | 70 | |
| 4 | Уулзалт хэлэлцүүлэгт оролцох | 60 | 10 | 70 | |
| 5 | Уулзалт хэлэлцүүлэгт оролцох | 60 | 10 | 70 | |
| 6 | Илтгэл танилцуулах | 60 | 10 | 70 | |
| 7 | Танилцуулга хийх | 60 | 10 | 70 | |
| 8 | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнүүдэд хичээл заах | 60 | 10 | 70 | |
| 9 | Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах | 60 | 10 | 70 | |
| 10 | Гадаад худалдаанд оролцогч нарт хичээл заах | 60 | 10 | 70 | |
| 11 | Цахимаар бараагаа мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт хичээл заах | 60 | 10 | 70 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Удирдлагын академид ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах. | 100 | 15 | |
| 2 | TABLEAU DESKTOP сургалтад хамрагдах. | 80 | 12 | |
| 3 | Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах. | 90 | 13.5 | |
| | **Дундаж оноо** | | 13.5 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|

| | 1 | 2 | 3 |
|---|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо** | | **6.6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| **Д/д** | **Үнэлгээний үзүүлэлт** | **Үзүүлэлт тус бүрийн оноо** |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)* | *65.8* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13.5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |

35

| **Нийт оноо =**<br><br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | 93.9 |
|---|---|

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Б.Даваасүрэн)

........................*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .............................. (Д.Ням-Осор)

........................*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

12/20, 2024 ........................ *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2024. 12. 20 .............................. *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***

Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

.............................. *(огноо)*